

ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠳᠢᠲᠤᠨ ᠭᠠᠰᠠᠷ
ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ 2025 ᠣᠨᠢ ᠨᠢᠭᠳᠤᠰᠢᠨ
ᠲᠦᠰᠪᠢᠶᠢᠨ ᠭᠦᠢᠴᠡᠲᠭᠡᠯᠳᠤ ᠬᠢᠶᠢᠰᠢᠨ
ᠠᠭᠳᠢᠲᠤᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠨ

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

2026 он



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/14

Алтай хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говь-Алтай аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн шийдвэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан хугацаанд, шийдвэрийн хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Г.Чинбат)-д зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Д.Цэрэнханд)-т үүрэг болгосугай.


5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.



Г.ГҮНЖИДМАА

822501000028

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2026 оны 04
дугаар сарын 24-ны өдрийн АНУ дугаар
тушаалын хавсралт



Аудитаар өгсөн шийдвэрийн жагсаалт

д/д	Хариуцагч	Шийдвэрийн			Зөрчлийн дүн (мян.төг)
		Төрөл	Огноо	Дугаар	
1	Говь-Алтай аймгийн Засаг дарга	Албан шаардлага	2026.04.24	01/103	-
2	Говь-Алтай аймгийн Засаг дарга	Албан шаардлага	2026.04.24	02/103	-

Тайлан бэлтгэсэн:

АГУУЛГА

Дарга, Тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ 3
	ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 4
	I БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ 5
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт 5
	1.2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 5
	II БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ 8
Ахлах аудитор: Д.Цэрэнханд	2.1 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт 8
	2.2 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 9
	2.2.2 Засаг даргын нөөц хөрөнгө..... 12
	2.2.3 Орон нутгийн хөгжлийн сан 13
Аудитор: Н.Гэрэлмаа Э.Сүнжидмаа	2.2.4 Хоршоо хөгжүүлэх сан..... 14
	III БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ 16
	4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 16
	4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 17
	4.3 Бусад хууль тогтоомжийн хүрээн дэх нийцлийн аудитын асуудал:..... 17
	IV БҮЛЭГ. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 18
2026 оны 04 дүгээр сар	V БҮЛЭГ. ТӨСВИЙН ТОДОТГОЛ, ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ 19
	5.3 Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийн талаар:..... 21
Уг тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn	VI АУДИТЫН ДҮГНЭЛТ 21
	6.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:..... 22

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал дараах утсаар харилцана уу.

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70483413 дугаар утсаар харилцана уу

ХАЯГ:
Говь-Алтай аймаг
Есөнбулаг сум
Жинст баг
Хөгжил хороолол 1402



Товчилсон үгийн жагсаалт

1	ААН	Аж ахуйн нэгж
2	ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
3	ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
4	АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
5	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
6	ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
7	ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
8	ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
9	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
10	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
11	ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
12	ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
13	ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
14	ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
15	УИХ	Улсын Их Хурал
16	УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
17	ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

Хүснэгтийн тайлбар

Хүснэгт 1	Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөлт
Хүснэгт 2	Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын гүйцэтгэл
Хүснэгт 3	Орон нутгийн 2025 оны нийт орлого /сумдаар/
Хүснэгт 4	Тусламж санхүүжилтийн орлого
Хүснэгт 5	Орон нутгийн 2025 оны төсвийн зардал, нийт тэнцэл
Хүснэгт 6	Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн
Хүснэгт 7	Аймгийн Засаг даргынхэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт
Хүснэгт 8	Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /сумдаар/
Хүснэгт 9	Засаг даргын нөөц хөрөнгөний зарцуулалт
Хүснэгт 10	ОНХС-ийн орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 11	Сумдын ХХС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 12	ХХС-гийн хугацаа хэтэрсэн зээлийн шийдвэрлэлт
Хүснэгт 13	Аймгийн 2025 оны төсвийн тодотгол
Хүснэгт 14	Төсвийн төсөлд өгсөн санал, хэрэгжилт
Хүснэгт 15	Төсвийн гүйцэтгэлийн хураангуй тайлан

Дүрслэлийн тайлбар

Дүрслэл 1	Засаг дарга ерөнхий дансны зарцуулалтын судалгаа
-----------	--

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.42 дахь заалтын дагуу Говь-Алтай аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аудитын зорилт

Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ

Говь-Алтай аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлд дараах бүрэлдэхүүнээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
- Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл
- Нэмэлт төсвийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан
- Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- Төсвийн тодотгол, төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлт

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000, Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн болон бусад холбогдох хэлтэс, сумдын төсөвт байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитор Э.Сүнжидмаа, Н.Гэрэлмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа хэрэгжүүлсэн.

¹ 8.1. Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

² 8.9.4. аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хангуулахаар ажилласан байна.

Төрийн аудитын газраас Говь-Алтай аймгийн 2025 оны төсвийн төсөлд тусгагдсан татварын болон татварын бус орлогыг 1,425.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, суурь зарлагыг 4,094.4 сая төгрөгөөр бууруулах, хөрөнгө оруулалтын зардлыг 2,760.0 сая төгрөгөөр бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх 8, нийт 8,279.5 сая төгрөгийн саналыг хүргүүлсэн.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 19,693.6 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийг 18,303.7 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Говь-Алтай аймгийн 2025 оны татварын ба татварын бус орлого, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос бүрдэх эх үүсвэрийг нийт 80,244.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 73,830.5 сая төгрөг зарцуулжээ.

Тайлант оны төсвийн орлогын гүйцэтгэл 109.0 хувь, зарлагын гүйцэтгэл 81.0 хувьтай байна. Аймгийн 2025 оны төсвийн саналыг онлайнд суурилсан FISCAL-B системээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд орон нутгийн төсвийн 45, төсөл сан 40, төрийн сангийн нэгж 21, хяналтад байгаа 12, орон нутгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилт авч байгаа 99, нийт 217 нэгжийн тайланг хамруулсан байна.

Тайлант онд аймгийн төсөвт 1 удаа тодотгол хийсэн бөгөөд анх орлого, зарлагыг 74,917.1 сая төгрөгөөр баталж, сүүлийн тодотголоор 12,829.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

I БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт

Аймгийн 2025 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журам, аймгийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрхзүйн актуудыг үндэслэн төлөвлөж, төсвийн төслийн саналыг FISCAL-B системд оруулснаар Сангийн яам хянаж, баталгаажуулсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны Төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн орон нутгийн төсвийн суурь орлогыг 32,135.9 сая төгрөгөөр тооцож төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлж, хянуулсан байна.

Тайлант 2025 онд төсвийг 1 удаа тодотгон баталсан бөгөөд сүүлийн тодотгосон төсвөөр аймгийн төсвийн орлогыг 12,509.1 сая төгрөгөөр, сумдын төсвийн орлогыг 28,911.1 сая төгрөгөөр, нийт 41,420.2 сая төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1. Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөлт

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төсвийн төсөл	Сангийн яамны хянасан дүн	2025 он		(сая төгрөг) Анх баталсан дүнгээс өссөн/буурсан
					Анх баталсан	Тодотгол 1	
1	Орон нутгийн орлого	35,294.1	32,135.9	32,135.9	25,019.3	41,420.2	16,400.9

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2025 оны тогтоол, Засаг даргын 2025 оны төсвийн төсөл

Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг нийт 41,420.2 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 6,126.1 сая төгрөгөөр, төсвийн төсөл, Сангийн яамны хянасан дүнгээс 9,284.3 сая төгрөгөөр, анх баталсан төсвөөс 16,400.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Тайлант 2025 оны орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 4,282.1 сая төгрөгөөр, хувь хүний орлогын албан татварын орлогыг 1,493.3 сая төгрөгөөр, бусад орлогууд 984.2 сая төгрөгөөр нийт 6,759.6 сая төгрөгөөр давсан байна.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Төсөвт байгууллагын өөрийн орлогын 2.9 сая төгрөгөөр бодитой төлөвлөөгүй. (Эрдэнэ сумын ЗДТГ-2.2 сая төгрөг, Шарга сумын ЗДТГ-0.7 сая төгрөг)

1.2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн орлогыг 41,420.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс 116.0 хувиар буюу 6,759.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь өмнөх оны гүйцэтгэлээс 12,885.7 сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 95.0 хувийг татварын, 5.0 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Хүснэгт 2. Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын гүйцэтгэл

(сая төгрөг)

Үзүүлэлт	2024 он		2025 он		
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	35,294.1	41,420.2	48,179.8	116.3	(6,759.6)
Татварын орлого	32,928.7	39,319.6	45,851.6	116.6	(6,532.0)

Орлогын албан татвар	26,784.8	32,519.2	38,295.3	117.8	(5,776.1)
Хөрөнгийн албан татвар	3,493.7	2,521.2	3,032.6	120.3	(511.4)
Бусад татвар төлбөр хураамж	2,650.2	4,279.2	4,523.7	105.7	(244.5)
Татварын бус орлого	2,365.4	2,100.6	2,328.2	110.8	(227.6)
Нийтлэг бус татварын орлого	2,071.3	1,950.3	2,252.1	115.5	(301.8)
Хөрөнгийн орлого	294.1	150.3	76.1	50.6	74.2

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 6,759.6 сая төгрөгөөр давсан нь ААНОАТ-ын орлого 4,282.1 сая төгрөгөөр, хувь хүний орлогын албан татвар 1,493.3 сая төгрөгөөр давж орсон нь голлон нөлөөлсөн байна.

Дүрслэл 1: Орон нутгийн орлогын сүүлийн 3 жилийн харьцуулсан судалгаа

(сая төгрөг)



Сүүлийн 3 жилийн орон нутгийн төсвийн орлогыг харьцуулахад 2023 онд 1,161.5 сая төгрөгөөр, 2025 онд 6,759.6 сая төгрөгөөр тус тус давсан бол 2024 онд 5,320.0 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна. Жил бүр орон нутгийн орлого тогтмол өсөлттэй байгаа нь эдийн засаг, инфляцийн түвшин, санхүү мөнгөний төсвийн бодлоготой шууд хамааралтай байна.

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023, 2024, 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Давсан орлогын шалтгаан тайлбар:

- ААНОАТ 4,282.0 сая төгрөгөөр давсан нь Хан-Алтай ресурс ХХК-ийн борлуулалтын орлого өссөнтэй,
- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 1,571.5 сая төгрөгөөр давж биелсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгодог болсонтой, “Хан-Алтай Ресурс” ХХК нь татварыг аймагт төвлөрүүлдэг болсонтой,
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 258.2 сая төгрөгөөр давсан нь орон сууцны борлуулалт нэмэгдсэнтэй,
- Малын тоо толгойн албан татвар 177.7 сая төгрөгөөр давсан нь малын тоо толгой өссөнтэй,
- Дуудлага худалдааны орлого 182.2 сая төгрөгөөр давсан нь 8 сумд газрын дуудлага худалдааг зохион байгуулсныг тодотголоор нэмж төлөвлөөгүйтэй,
- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 59.2 сая төгрөгөөр давсан нь 2022 онд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээ нэмэгдсэнтэй,
- Үйл ажиллагааны орлого 56.8 сая төгрөгөөр давсан нь Төрийн сангийн удирдлагын цахим системийг 2023 оны 1 дүгээр сараас бүрэн нэвтрүүлж эхэлсэн бөгөөд худалдаа, үйлчилгээ, хувиараа бизнэс эрхлэгч иргэдийн татварын цахим системд үүсгэсэн төлбөрийн нэхэмжлэхэд үндэслэн төлбөр тооцоог гүйцэтгэж байгаатай,

- Газрын төлбөрийн орлого 37.4 сая төгрөгөөр давсан нь урьд онуудын төлбөрийг барагдуулсантай,
- Түрээсийн орлого 24.2 сая төгрөгөөр давсан нь түрээсийн төлбөрийн орлогыг Аймгийн ИТХ-ын 2023 оны 56 дугаар тогтоолын дагуу түрээсийн гэрээг Орон нутгийн өмчийн газраар батлуулан, нийт төвлөрөх түрээсийн орлогын 40 хувийг аймгийн төсвийн орлогод оруулахаар тусгасантай,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 22.6 сая төгрөгөөр давсан нь Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ нь цахим систем ашиглан Есөнбулаг сумын айл өрхөөс авах хог хаягдлын үйлчилгээний хураамжийг авдаг болсонтой,
- Хөрөнгө борлуулсны орлого 19.5 сая төгрөгөөр давсан нь тайлант онд шинээр ашиглалтад орсон нийтийн орон сууцны борлуулалт нэмэгдсэнтэй,
- Бууны албан татварын орлого 16.3 сая төгрөгөөр давсан нь галт зэвсэгийн улсын үзлэг тооллогоор Татварын газар болон Цагдаагийн газар галт зэвсгийн бүртгэл, хөдөлгөөний мэдээллийг тулган баталгаажуулж тоо мэдээлэлд хяналт тавин ажилласантай,
- Ан амьтны нөөц ашигласны төлбөрын орлого 11.4 сая төгрөгөөр давсан нь Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамнаас тусгай зориулалтын ан агнуурын зөвшөөрөл олгосныг төлөвлөөгүйтэй,
- Улсын тэмдэгтийн хураамж 8.1 сая төгрөгөөр давсан нь төрөөс авах иргэдийн үйлчилгээ нэмэгдсэнтэй,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 6.1 сая төгрөгөөр давсан нь бүтээн байгуулалтын ажил хийж байгаа ААН-үүд орлого төвлөрүүлж байгаатай тус тус холбоотой байна.

Тасарсан орлогын шалтгаан тайлбар:

- Хөрөнгийн орлого 95.7 сая төгрөгөөр тасарсан нь Монгол банкны бодлогын хүүгийн түвшинтэй уялдан арилжааны банкны хадгаламжийн хүү буурсантай,
- Шууд бус орлого 58.8 сая төгрөгөөр тасарсан нь иргэдэд олгосон хувьцааны ногдол ашиг буурсантай,
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрын орлого 26.9 сая төгрөгөөр тасарсан нь уул уурхайн зарим компани үйл ажиллагаа явуулаагүйгээс,
- Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөрын орлого 0.1 сая төгрөгөөр тасарсан нь хяналт шалгалт сул байгаагаас иргэд сайн дураарай төлөхгүй байгаатай,
- Өмч хувьчлалын орлого 74.2 сая төгрөгөөр тасарсан нь төлөвлөсөн 4 барилгын өмч хувьчлал явагдаагүйтэй тус тус холбоотой байна.

Орон нутгийн нийт орлого 6,759.6 сая төгрөгөөр давсан нь аймаг 4,865.7 сая төгрөгөөр, Есөнбулаг сум 903.7 сая төгрөгөөр, Тайшир сум 211.1 сая төгрөгөөр, Дарив сум 152.5 сая төгрөгөөр, Цээл сум 140.1 сая төгрөгөөр, Алтай сум 129.9 сая төгрөгөөр, Тонхил сум 112.8 сая төгрөгөөр давсан нь голлон нөлөөлсөн байна. Тайлант онд Бигэр сум 4.7 сая төгрөгөөр орон нутгийн орлого тасарсан.

Хүснэгт 3. Орон нутгийн 2025 оны нийт орлого (сумдаар)

(сая төгрөг)

Сум, байгууллага	Орлого				Сум, байгууллага	Орлого			
	Төл	Гүйц	Хувь	Зөрүү		Төл	Гүйц	Хувь	Зөрүү
Алтай	1,221.3	1,351.2	110.6	(129.9)	Хөхморьт	583.7	619.5	106.1	(35.8)
Баян-Уул	640.0	651.7	101.8	(11.7)	Цогт	632.7	634.5	100.3	(1.8)
Бигэр	549.6	544.9	99.1	4.7	Цээл	753.6	893.70	118.6	(140.1)
Бугат	582.6	590.2	101.3	(7.6)	Чандмань	858.6	899.8	104.8	(41.2)
Дарив	389.6	542.1	139.1	(152.5)	Шарга	387.4	434.3	112.1	(46.9)
Дэлгэр	578.7	579.8	100.2	(1.1)	Эрдэнэ	729.7	747.8	102.5	(18.1)
Жаргалан	420.9	435.2	103.4	(14.3)	Гуулин	205.7	211.2	102.7	(5.5)
					тосгон				



Тайшир	483.2	694.4	143.7	(211.2)	Баянтоорой тосгон	262.2	293.7	112.0	(31.5)
Тонхил	548.5	661.3	120.6	(112.8)	Есөнбулаг	18,005.8	18,909.5	105.0	(903.7)
Төгрөг	647.4	655.6	101.3	(8.2)	Аймаг	12,509.1	17,374.8	138.9	(4,865.7)
Халиун	430.0	454.4	105.7	(24.4)					
					Нийт дүн	41,420.2	48,179.9	116.3	(6,759.7)

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн байгууллагын өөрийн орлогыг 1,011.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,948.4 сая төгрөг буюу 937.2 сая төгрөгөөр давж биелсэн нь өөрийн орлогын төлөвлөлтийг бодитой төлөвлөхгүй байгааг харуулж байна.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Төрийн сангууд нь харьяа төсвийн байгууллагуудад **501.6 сая төгрөгийн татаас санхүүжилтийг** илүү, дутуу олгосон. (Есөнбулаг сум-175.3 сая төгрөг, Тонхил сум-84.4 сая төгрөг, Чандмань сум-45.8 сая төгрөг, Цогт сум-45.4 сая төгрөг, Жаргалан сум-42.1 сая төгрөг, Хөхморьт сум-40.0 сая төгрөг, Баянтоорой-19.3 сая төгрөг, Шарга сум-18.9 сая төгрөг, Төгрөг сум-16.9 сая төгрөг, Баян-Уул сум-10.8 сая төгрөг, Дэлгэр сум-2.7 сая төгрөг)
- Сумдын орон нутгийн орлогыг төлөвлөгөө **491.6 сая төгрөгөөр тасарсан.** (Тонхил сум-79.0 сая төгрөг, Эрдэн сум-61.2 сая төгрөг, Баян-Уул сум-53.7 сая төгрөг, Дэлгэр сум-42.5 сая төгрөг, Халиун сум-40.9 сая төгрөг, Дарив сум-37.5 сая төгрөг, Цогт сум-32.3 сая төгрөг, Бигэр сум-27.4 сая төгрөг, Бугат сум-24.1 сая төгрөг, Цэцэг сум-21.8 сая төгрөг, Шарга сум-19.2 сая төгрөг, Чандмань сум-16.7 сая төгрөг, Гуулин тосгон-15.9 сая төгрөг, Жаргалан сум-13.2 сая төгрөг, Хөхморьт сум-3.8 сая төгрөг, Төгрөг сум-2.2 сая төгрөг, Баянтоорой тосгон-0.2 сая төгрөг)
- Малын тоо толгойн албан татварын орлого **102.4 сая төгрөгийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлээгүй.** (Есөнбулаг-58.5 сая төгрөг, Тонхил сум-39.2 сая төгрөг, Цогт сум-3.2 сая төгрөг, Дэлгэр сум-0.5 сая, Төгрөг сум-0.5 сая төгрөг, Шарга сум-0.5 сая төгрөг)
- Орлогын төлөвлөгөө **20.0 сая төгрөгөөр тасарсан.** (Инноваци бизнес хөгжлийн төв УТҮГ)
- Өвс тэжээлийн **6.8 сая төгрөгийг дансанд төвлөрүүлээгүй** (Гуулин тосгоны Захирагчийн алба)
- Түрээсийн орлого **3.6 сая төгрөгийг төвлөрүүлээгүй.** (Төгрөг сумын ЗДТГ-1.2 сая төгрөг, Тонхил сумын ЗДТГ-1.1 сая төгрөг, Шарга сумын ЗДТГ-0.7 сая төгрөг, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-0.5 сая төгрөг)

Хүснэгт 4. Тусламж санхүүжилтийн орлого

(сая төгрөг)

Үзүүлэлт	2024 он		2025 он		
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
ОНХС-ийн нэгдсэн сангаас	16,596.2	18,303.8	18,128.6	99.0	175.2
Тусламж/ Шилжүүлэг	26,065.0	19,659.5	19,659.5	100.0	0.0
дүн	42,661.2	37,963.3	37,788.1	199.0	175.2

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Говь-Алтай аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 19,659.5 сая төгрөг, ОНХС-ийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 18,303.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс авах дэмжлэгийг бүрэн, ОНХС-ийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 175.2 сая төгрөгөөр дутуу авсан байна.

II БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт

Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь зарлагын дүнг 61,661.1 сая төгрөгөөр хянасан бөгөөд аймаг, сумдын ИТХ-аас анх 100,309.8 сая төгрөгөөр баталсан байна.



Аймгийн төсөвт тодотголыг хийж, орон нутгийн төсвийн суурь зардлыг 90,182.1 сая төгрөг буюу 10,127.7 сая төгрөгөөр бууруулж баталсан нь улсын төсвөөс авах шилжүүлэг буурсантай холбоотой байна.

Хүснэгт 5. Орон нутгийн 2025 оны төсвийн зарлага

Үзүүлэлт	Төсвийн төсөл	Сангийн яамны хянасан дүн	2025 он		(сая төгрөг) Анх баталсан дүнгээс өссөн/буурсан
			Анх баталсан	Тодотгол 1	
Нийт зарлага	67,890.8	61,661.1	100,309.8	90,182.1	10,127.7

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2025 оны тогтоол, Аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн төсөл

2.2 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Тайлант оны орон нутгийн төсвийн нийт зарлага 73,830.6 сая төгрөг буюу 81.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 6. Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн

Үзүүлэлт	2024 он		2025 он		
	Гүйцэтгэл	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	76,355.0	90,182.1	73,830.6	81.9	16,351.5
А. Урсгал зардал	55,024.6	61,141.8	57,403.2	93.9	3,738.6
Бараа, ажил үйлчилгээний зардал	52,924.5	59,485.6	56,315.8	94.7	3,169.8
Урсгал шилжүүлэг	1,720.4	1,319.7	917.0	69.5	402.7
Б. Хөрөнгийн зардал	20,976.7	26,506.0	15,633.6	59.0	10,872.4
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	353.7	2,534.3	793.7	31.3	1,740.6

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 77.7 хувийг урсгал зардал, 21.2 хувийг хөрөнгийн зардал, 1.1 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

Урсгал зардлын хэмжээ сүүлийн 5 жилд дунджаар 75.0 хувьтай байгаа нь төсвийн үр ашгийг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих дунд болон урт хугацааны бодлоготой бүрэн уялдаагүй байна.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл өмнөх оноос 440.0 сая төгрөгөөр буурч, хөрөнгийн зардал 5,343.1 сая төгрөгөөр, урсгал зардал 2,378.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт зардал 3.3 хувиар буурсан байна. Энэ нь Сангийн яамнаас зардал хязгаарлаж данс хаасантай холбоотой байна.

Удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтнуудад Тайшир сумын ЗДТГ 17.2 сая төгрөг, Баян-Уул сумын ЗДТГ 11.4 сая төгрөг нийт 28.6 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгож, буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон байна.

Хүснэгт 7. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт (сая төгрөг)

№	Хөтөлбөр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	5,260.9	4,790.5	470.4	91.1
2	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	37,976.5	35,067.0	2,909.5	92.3

3	70417	Мэргэжлийн хяналт	369.9	348.3	21.6	94.2
4	70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	427.1	383.6	43.5	89.8
5	70503	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	23,932.5	14,126.3	9,806.2	59.0
6	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	60.0	48.9	11.1	81.5
7	70802	Газар тариалан хөгжүүлэх	50.0	0.8	49.2	1.6
8	71403	Ойжуулалт	318.7	292.9	25.8	91.9
9	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,848.0	1,702.2	145.8	92.1
10	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	2,865.0	2,767.4	97.6	96.6
11	71701	Биеийн тамир спорт	418.2	416.2	2.0	99.5
12	71702	Соёл урлаг	2,258.0	2,207.5	50.5	97.8
13	71801	Сургуулийн өмнөх боловсрол	2,083.2	1,938.1	145.1	93.0
14	71802	Ерөнхий боловсрол	8,441.3	7,864.3	577.0	93.2
15	71804	Мэргэжлийн боловсрол	772.3	765.3	7.0	99.1
16	71806	Насан туршийн болон албан бус боловсрол	14.2	13.2	1.0	93.0
17	71902	Нийгмийн халамж	110.0	108.0	2.0	98.2
18	72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,976.3	990.1	1,986.2	33.3
		Дүн	90,182.1	73,830.6	16,351.5	81.9

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 18 хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд газар тариалан хөгжүүлэх хөтөлбөрийн гүйцэтгэл 1.6 хувьтай, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн гүйцэтгэл 33.3 хувьтай, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт 59.0 хувьтай, бусад хөтөлбөрийн хувьд 81.5-99.5 хувьтай байна.

Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн (сумдаар)

(сая төгрөг)

Сум, байгууллага	Зарлага				Сум, байгууллага	Зарлага			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Алтай	3,461.8	2,431.7	70.2	1,030.1	Хөхморьт	2,730.8	2,370.2	86.8	360.6
Баян-Уул	2,564.6	2,286.7	89.2	277.9	Цогт	3,041.1	2,636.1	86.7	405.0
Бигэр	2,700.4	1,633.3	60.5	1,067.1	Цээл	1,935.8	1,567.7	81.0	368.1
Бугат	2,287.3	1,752.7	76.6	534.6	Чандмань	2,424.8	1,910.3	78.8	514.5
Дарви	1,871.9	1,545.6	82.6	326.3	Шарга	2,071.2	1,805.8	87.2	265.4
Дэлгэр	2,538.6	2,216.1	87.3	322.5	Эрдэнэ	2,747.0	2,345.7	85.4	401.3
Жаргалан	1,824.4	1,595.5	87.5	228.9	Гуулин тосгон	525.7	411.2	78.2	114.5
Тайшир	1,875.9	1,729.2	92.2	146.7	Баянтоорой тосгон	671.8	634.2	94.4	37.6
Тонхил	2,592.3	2,171.1	83.8	421.2	Есөнбулаг	23,433.5	21,677.2	92.5	1,756.3
Төгрөг	2,299.2	1,981.6	86.2	317.6	Аймгийн шууд	24,203.8	17,162.2	70.9	7,041.6
Халиун	2,380.2	1,966.5	82.6	413.7					
		Нийт дүн				90,182.1	73,830.6	81.9	16,351.5

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн төсвийн төлөвлөсөн нийт зарлага 90,182.1 сая төгрөг, гүйцэтгэл 73,830.6 сая төгрөг буюу 81.9 хувьтай байна. Нийт гүйцэтгэлээрх зарлагын 29.3 хувь буюу 21,677.2 сая төгрөгийг Есөнбулаг сум, 23.2 хувь буюу 17,162.2 сая төгрөгийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, 47.5 хувь буюу 34,991.2 сая төгрөгийг сумдын байгууллагууд эзэлж байна.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Кассын дансаар 314.1 сая төгрөгийг дамжуулан гүйлгээ хийсэн бөгөөд, бэлэн мөнгөний орлого, зарлагын тайлангүй. (Аймгийн ЗДТГ 2 дугаар тайлан-157.1 сая төгрөг, аймгийн ЗДТГ -131.1 сая төгрөг, Халин сумын ЗДТГ-13.9 сая төгрөг, Ахмадын хороо-12.0 сая төгрөг)
- Төсвийн төсөл, баталсан төсөвт тусгаагүй 273.3 сая төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт, урамшуулал олгосон. (Есөнбулаг сумын ЗДТГ-128.1 сая төгрөг, Төгрөг сумын ЗДТГ-43.1 сая төгрөг, аймгийн ЗДТГ-40.3 сая төгрөг, Хөхморьт сум-32.7 сая төгрөг, Тайшир сум-24.1 сая төгрөг, Халиун сумын ИТХ-5.0 сая төгрөг)
- Төсвөөс 143.7 сая төгрөгийн шатахууныг албан бус хэрэгцээнд зарцуулсан, зарцуулалт тодорхой бус, няравын тайлан гаргадаагүй. (аймгийн ЗДТГ-138.5 сая төгрөг, Есөнбулаг сумын ИТХ-5.2 сая төгрөг)
- Ажиллагсад 84.8 сая төгрөгийн цалин илүү, урамшуулал, амралт, тэтгэмж илүү дутуу олгосон. (Төгрөг сумын ЗДТГ-13.1 сая төгрөг, Бигэр сумын ЗДТГ-11.2 сая төгрөг, Алтай сумын ЗДТГ-8.7 сая төгрөг, Цогт сумын ИТХ-6.4 сая төгрөг, Баянтоорой тосгоны Захирагчийн алба-6.3 сая төгрөг, Баян-Уул сумын ЗДТГ-5.8 сая төгрөг, Худалдан авах ажиллагааны газар-5.2 сая төгрөг, Эрдэнэ сумын ЗДТГ-4.2 сая төгрөг, Гуулин тосгоны Захирагчийн алба-3.6 сая төгрөг, Чандмань сумын ЗДТГ-3.1 сая төгрөг, Цогт сумын ЗДТГ-3.1 сая төгрөг, Дэлгэр сумын ЗДТГ-2.8 сая төгрөг, Халиун сумын ЗДТГ-2.5 сая төгрөг, Дэлгэр сумын ИТХ-1.5 сая төгрөг, Цээл сумын ЗДТГ-1.3 сая төгрөг, Ундарга-Алтай ААТҮГ-1.2 сая төгрөг, Есөнбулаг сумын ИТХ-1.1 сая төгрөг, Бугат сумын ЗДТГ-0.9 сая төгрөг, Жаргалан сумын ЗДТГ-0.9 сая төгрөг, Хөхморьт сумын ИТХ-0.7 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-0.6 сая төгрөг, Ахмадын хороо-0.6 сая төгрөг)
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн, төсвийн хэлбэлзлийг 55.5 сая төгрөгөөр зөрүүтэй. (Халамжийн сан-23.6 сая төгрөг, Жаргалан сумын ЗДТГ-13.6 сая төгрөг, Тонхил сумын ЗДТГ-12.5 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-4.7 сая төгрөг, Дэлгэр сумын ЗДТГ-1.1 сая төгрөг)
- Төсвөөс 28.6 сая төгрөгийн цалингийн нөхөн олговор олгож, төсөвт хохирол учруулсан. (Тайшир сумын ЗДТГ-17.2 сая төгрөг, Баян-Уул сумын ЗДТГ-11.4 сая төгрөг)
- Баталсан төсвийг 20.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. (Шарга сумын ЗДТГ)
- Байгууллагын дарга, ажилтны дансаар дамжуулан 14.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн, хөрөнгө худалдан авсан. (Дэлгэр сумын ЗДТГ-8.7 сая төгрөг, аймгийн ЗДТГ-4.1 сая төгрөг, Инноваци бизнес хөгжлийн төв УТҮГ-2.0 сая төгрөг)
- Цээл сумын ЗДТГ нь 4.7 сая төгрөгийг чиг үүрэгт хамааралгүй үйл ажиллагаанд зарцуулсан.
- Төсвөөс 4.5 сая төгрөгийг Бүгд найрамдах солонгос Улсад чуулга уулзалтад оролцсон. (Есөнбулаг сумын ИТХ)

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Аймгийн хэмжээнд унаа хоолны хөнгөлөлт 210103 эдийн засгийн ангилалд 17 байгууллагын 312.1 сая төгрөгийн төсөв баталсан байхад гүйцэтгэлээр 28 байгууллагын 809.2 сая төгрөгийн хоолны зардал гарган, 497.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

2.2.1 Засаг дарга ерөнхий дансны талаар:

Аймгийн төсвийн нийт урсгал зардлын 28.7 хувь буюу 4,937.1 сая төгрөгийг Засаг дарга Ерөнхий данснаас зарцуулсан байна.

Төсвийн тухай хууль тогтоомжид Засаг дарга ерөнхий дансны талаар тусгагдаагүй бөгөөд аймгийн ИТХ-аас Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ, бусад зардлыг санхүүжүүлэхээр баталдаг байна.

Говь-Алтай аймгийн Засаг даргын багцын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 онд боловсруулан, 2021 оны А/606 захирамжаар баталсан байна. Уг бодлогын баримт бичгийн 4.5-д тусгай сангуудын бүртгэл, тайлагнал хэсэгт "төсвийн аль нэг төвлөрүүлэн эсвэл шууд захирагчид хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээнүүдийг холбогдох дүрэм, журамд тусдаа данстай байхаар заагаагүй бол ИТХ-аар Засаг дарга дансанд нэгтгэн батална" гэж тусгасан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4³, 18 дугаар зүйлийн 18.4⁴ дэх заалтуудтай нийцэхгүй байна.

³ Төсвийн ерөнхий данс" гэж тухайн шатны төсвийн мөнгөн гүйлгээг нэгтгэн бүртгэх харилцах дансыг;

⁴ Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна.

Дүрслэл 1: Засаг дарга ерөнхий дансны зарцуулалтын судалгаа

(сая төгрөг)



Засаг дарга ерөнхий дансны санхүүжилт жилээс жилд нэмэгдэж, 2020 онд 380.5 сая төгрөг, 2021 онд 602.5 сая төгрөг, 2022 онд 1,169.5 сая төгрөг, 2023 онд 2,706.0 сая төгрөг, 2024 онд хамгийн өндөр буюу 9,215.0 сая төгрөг байсан 2025 онд 4,937.1 сая төгрөг болж буурсан байна. Учир нь аймгийн ИТХ-ын 2025 оны 39 дүгээр тогтоолоор уг данснаас 2,689.7 сая төгрөгийг хасах тодотгол хийсэнтэй холбоотой байна.

Засаг дарга ерөнхий дансны зарцуулалтыг Сангийн яамнаас хянаагүй ба нийт зарцуулалтын 42.0 хувь буюу 2,073.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, сургалт, судалгаа болон буудал, албан томилолт, иргэн, төрийн бус байгууллагын дэмжлэг, бэлэг дурсгал, шагнал, урамшуулал зэрэг үйл ажиллагаанд зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг давтан гаргасан.

Засаг дарга дансны санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Байгууллагын нэр дээрх 5315620466 тоот картын дансаар дамжуулан, ангилагдаагүй бусад арга хэмжээний зардлаас 157.0 сая төгрөгийн 17 гүйлгээг бэлнээр касст гарган авч зарцуулсан ба бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээний анхан шатны баримтгүй,
- Элсэлтийн ерөнхий шалгалтын ном 9.6 сая төгрөгөөр, төрийн албан хаагчдад монгол бичгийн ном 10.0 сая төгрөгөөр авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан,
- Гандантэгчлэн хийдийн үйл ажиллагаанд 10.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин аймгийн баяр наадмын зардлаас 6.0 сая төгрөгийг айраг худалдан авсан,
- Төсвөөс санхүүчдийн баярын хүлээн авалтын зардалд 5.0 сая төгрөгийг төлсөн, төсвөөс аж ахуйн салбарын баярын хүлээн авалтын зардалд 3.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Сангийн яамнаас хянаагүй Засаг дарга ерөнхий данснаас ангилагдаагүй бусад арга хэмжээний зардалд 2,073.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, сургалт, судалгаа болон буудал, албан томилолт, иргэн, төрийн бус байгууллагын дэмжлэг, бэлэг дурсгал, шагнал, урамшуулал зэрэг үйл ажиллагаанд зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг давтан гаргасан.

2.2.2 Засаг даргын нөөц хөрөнгө

Аймаг, сумдын ЗДТГ-ын бүтцэд орон нутгийн нөөц хөрөнгө буюу Засаг даргын нөөц хөрөнгө 1 хөтөлбөр, арга хэмжээ болон хэрэгжиж байна. Тайлант 2025 онд 1,936.1 сая төгрөгийг зарцуулахаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 1,818.9 сая төгрөгийг зарцуулсан ба 94.0 хувьтай байна.

Хүснэгт 9. Засаг даргын нөөц хөрөнгөний зарцуулалт

(сая төгрөг)

№	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үүнээс: ТХТХ зөрчсөн	Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар дагуу шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин 2024 онд 611.2 сая төгрөгийн зарцуулалт гаргасан бол 2025 онд 734.9 сая төгрөг болж 123.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
1	Алтай	30.0	23.4	6.9	
2	Баян-Уул	8.0	8.0	-	
3	Бигэр	63.6	38.4	30.6	
4	Бугат	18.0	18.0	1.4	
5	Дарви	47.6	34.9	13.2	
6	Дэлгэр	9.8	9.7	2.5	
7	Жаргалан	20.0	17.7	-	
8	Тайшир	35.0	22.5	4.6	
9	Тонхил	80.0	70.1	19.8	
10	Төгрөг	17.5	17.4	5.1	
11	Халиун	72.0	68.9	24.3	
12	Хөхморьт	25.0	25.0	5.3	
13	Цогт	144.3	144.2	113.4	Тухайлбал: Цогт сум бусад сумтай харьцуулахад хамгийн өндөр буюу 2024 онд 170.5 сая төгрөгийг бэлэг дурсгал, буцалтгүй тусламж, дэмжлэг зэрэгт зориулалт бусаар зарцуулсан бол 2025 онд 113.4 сая төгрөгийг зарцуулсан байна.
14	Цээл	20.0	20.0	-	
15	Чандмань	35.2	32.3	8.8	
16	Шарга	30.0	27.2	3.6	
17	Эрдэнэ	137.2	119.8	2.2	
18	Есөнбулаг	214.0	203.4	160.0	
19	Аймаг	929.0	917.7	333.2	
	Дүн	1,936.1	1,818.9	734.9	

2.2.3 Орон нутгийн хөгжлийн сан

ОНХС-гийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 18,303.8 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 18,128.6 сая төгрөгийг санхүүжүүлж, 175.2 сая төгрөгийг дутуу олгожээ. Нийт санхүүжилтээс сумдад 9,748.8 сая төгрөг буюу 46.2 хувийг олгосон байна.

Хүснэгт 10. ОНХС-ийн орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

Сумын нэр	ОНХС-ийн орлого			Сумын нэр	ОНХС-ийн орлого		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Алтай	632.3	626.0	6.3	Хөхморьт	224.7	222.5	2.2
Баян-Уул	261.6	259.0	2.6	Цогт	557.6	552.0	5.6
Бигэр	411.6	407.5	4.1	Цээл	391.2	387.3	3.9
Бугат	402.0	397.9	4.1	Чандмань	197.2	195.2	2
Дарви	138.3	138.3	0.0	Шарга	288.4	285.5	2.9
Дэлгэр	344.3	340.8	3.5	Эрдэнэ	619.5	613.3	6.2
Жаргалан	142.7	142.7	0.0	Есөнбулаг	4,023.7	3,983.5	40.2
Тайшир	330.1	326.8	3.3	Аймаг	8,459.1	8,379.8	79.3
Тонхил	421.5	417.2	4.3				
Төгрөг	252.7	250.1	2.6				
Халиун	205.3	203.2	2.1				

Нийт дүн

18,303.8

18,128.6

175.2

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн ОНХС-аас нийт 8,459.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Гэрээний хугацаа дууссан байхад хүлээж аваагүй **1,847.3** сая төгрөгийн төсөл арга хэмжээ байна. (Аймгийн ОНХС-1,431.9 сая төгрөг, Тонхил сум 158.7 сая төгрөг, Хөхморьт сум-89.4 сая төгрөг, Бигэр сум-62.1 сая төгрөг, Дарив сум-54.2 сая төгрөг, Цогт сум-38.5 сая төгрөг, Эрдэнэ сум-12.5 сая төгрөг)
- ОНХС-ийг хөрөнгийг чиг үүрэгт хамаарахгүй **579.2** сая төгрөгийг хориглосон нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд зарцуулсан. (Аймгийн ОНХС-77.0 сая, Баян-Уул сум-76.5 сая, Цээл сум-60.0 сая, Халиун сум-53.2 сая төгрөг, Бигэр сум-45.3 сая төгрөг, Тонхил сум-44.6 сая төгрөг, Дэлгэр сум-42.7 сая төгрөг, Цогт сум-42.5 сая төгрөг, Дарив сум-32.5 сая, Төгрөг сум-26.5 сая, Хөхморьт сум-21.1 сая, Эрдэнэ сум-16.5 сая, Бугат сум-14.0 сая, Алтай сум-13.6 сая, Шарга сум-10.6 сая, Есөнбулаг сум-2.6 сая төгрөг)
- ОНХС-ийг хөрөнгөнөөс **118.5** сая төгрөг урсгал зардалд санхүүжүүлсэн, (Эрдэнэ сум-31.0 сая төгрөг, Шарга сум-29.6 сая төгрөг, Хөхморьт сум-27.3 сая төгрөг, Чандмань сум-21.8 сая төгрөг, Тонхил сум-4.9 сая төгрөг, Бугат сум-3.9 сая төгрөг)
- Цогт сумын ОНХС-гаас санхүүжилт **99.5** сая төгрөгийг гэрээний дагуу олгоогүй, Есөнбулаг сумын ОНХС-гаас 1.0 сая төгрөгийг гэрээний дүнгээс илүү шилжүүлсэн,
- Аймгийн ОНХС-гаас цэвэр цусны 1 азарга **73.0** сая төгрөгөөр худалдан авсан нь нийтийн эрх ашигт нийцээгүй,
- Аймгийн ОНХС-гаас санхүүжих **34.9** сая төгрөгийн төсөл арга хэмжээг Тонхил сумын ОНХС-гаас санхүүжүүлсэн.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн 2025 оны 75/215 дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргаж Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр заасан чиг үүрэгт хамаарахгүй, хориглосон буцалтгүй тусламж дэмжлэгийн шинжтэй хөтөлбөр, арга хэмжээнд буюу эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдад **800.0** сая төгрөгийн орон сууцны дэмжлэг олгосон.

8,379.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.2.4 Хоршоо хөгжүүлэх сан

ХХС-гийн зээлийн эргэн төлөлт 2024 онд 621.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,065.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн бол 2025 онд 631.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 884.1 сая төгрөгөөр төвлөрсөн нь 40.1 хувиар давж биелсэн байна.

Тус сангийн орлогын төлөвлөлтийг сумд үндэслэлтэй төлөвлөөгүй байна. Есөнбулаг сум 2.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 124.7 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна. Өмнөх онд Тонхил, Халиун сумууд тус сангийн орлогыг төлөвлөөгүй байсан бөгөөд энэ зөрчил 2025 онд арилаагүй давтан гарсан байна.

Иймд төсвийн төслийг хянаж үзэхдээ тусгай сангуудын орлогын тооцооллыг үндэслэлтэй үнэн зөв төлөвлөж байгааг харгалзан үзэх шаардлагатай.

Хүснэгт 11. Сумдын ХХС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

Сумын нэр	ХХС-ийн орлого			Сумын нэр	ХХС-ийн орлого		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Алтай	31.5	31.9	101.0	Төгрөг	18.0	19.7	109.0
Баян-Уул	30	45.4	151.0	Халиун	0	33.0	-
Бигэр	54.9	46.1	84.0	Хөхморьт	32.0	29.3	90.0

Бугат	20	31.4	157.0	Цогт	80.0	76.3	95.0
Дарви	20	36.5	183.0	Цээл	115.3	16.3	10.0
Дэлгэр	70	58.77	84.0	Чандмань	50.9	45.8	90.0
Жаргалан	36	25.0	69.0	Шарга	20.3	40	200.0
Тайшир	27	46.2	171.0	Эрдэнэ	23.1	35.4	153.0
Тонхил	0	17.7		Есөнбулаг	2.0	249.3	124.7
Нийт дүн					631.0	884.1	142.2

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн хэмжээнд 803.0 сая төгрөгийн зээл, хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бөгөөд тайлант онд 146.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

ХХС-гаас хугацаа хэтэрсэн зээлийн мэдээллээс харахад 238.9 сая төгрөгийн 24 зээлдэгчийг Шүүхэд шилжүүлж ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд 101.4 сая төгрөгийн 24 зээлдэгчийг Шүүхэд шилжүүлээгүй, 98.5 сая төгрөгийн 12 зээлдэгчийг Прокурорт шилжүүлсэн байна.

Хүснэгт 12. ХХС-гийн хугацаа хэтэрсэн зээлийн шийдвэрлэлт

Шийдвэрлэлт	(сая төгрөг)	
	ТАХ тоо	Мөнгөн дүн
Шүүхийн шийдвэр гарч, ШШГГ-тай гэрээ байгуулан ажиллагаа хийгдэж байгаа	24	238.9
Шүүхэд шилжүүлээгүй	24	101.4
Прокурорт шилжүүлсэн	12	98.5
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас буцаан татан авсан	13	87.9
Шүүхэд хандсан боловч хэрэгсэхгүй болгосон, хүлээн авахаас татгалзсан	6	59.6
Шүүхийн шатанд /Эвлэрлийн гэрээ байгуулсан/	6	25.7
Шүүхийн шийдвэр гарсан боловч ШШГА-тай гэрээ байгуулаагүй	5	22.0
Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хандаагүй	4	16.5
Шүүхэд хандаж төлүүлсэн боловч дутуу нэхэмжилснээс шүүх дахин авахгүй байгаа	5	5.9
НИЙТ ДҮН	99	656.4

Алтай, Дэлгэр, Есөнбулаг, Цогт, Хөхморьт, Чандмана, Эрдэнэ сумдын ХХС-гийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 12 иргэн, хоршоодын зээлийг төлүүлэх шүүхийн шийдвэр гарч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай гэрээ байгуулсан боловч 2019-2021 онд тухайн үеийн сумын Засаг дарга нар эргүүлэн татан авч зээлийг төлүүлээгүй, зээлийн үлдэгдэл 87.9 сая төгрөгийн 13 зээлдэгчийн мэдээллийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас буцаан татан авсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу)

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- ХХС-гийн 146.6 сая төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүүг хуваарьт хугацаанд төлүүлээгүй. (Цээл сум-26.8 сая төгрөг, Баян-уул сум-22.5 сая төгрөг, Цогт сум-17.6 сая төгрөг, Жаргалан сум-16.0 сая төгрөг, Дарив сум-15.8 сая төгрөг, Бигэр сум-10.4 сая төгрөг, Чандмань сум-10.4 сая төгрөг, Дэлгэр сум-9.7 сая төгрөг, Тонхил сум-4.6 сая төгрөг, Хөхморьт сум-3.7 сая төгрөг, Бугат сум-2.9 сая төгрөг, Алтай сум-2.9 сая төгрөг, Төгрөг сум-2.3 сая төгрөг, Тайшир сум-1.0 сая төгрөг)
- Цээл сум нь зээлийн гэрээний хугацаа дууссан 2.2 сая төгрөгийн зээлийг төлүүлэх талаар хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй, Цогт сум нь 2.4 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг зээлдэгчээр баталгаажуулаагүй, шүүхийн шийдвэрийг албан гүйцэтгэгчээр захирамж гарсан боловч гэрээ байгуулаагүй, Чандмань сум нь 2.1 сая төгрөгийн Хоршоо хөгжүүлэх сангийн бүртгэл хяналт нэгтгэлийн системд зээлдэгчийн мэдээлэл зөрүүтэй, зээлийн өргүй эсэх тодорхойгүй байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг Тонхил, Халиун сумууд огт төлөвлөөгүй боловч 50.7 сая төгрөг төвлөрч, Есөнбулаг сум 2.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 249.2 сая төгрөг төвлөрүүлсэн нь бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,606.1 сая төгрөгийн 278 зөрчил илэрснээс 397.1 сая төгрөгийн 48 төлбөрийн акт тогтоож, 2,912.9 сая төгрөгийн зөрчилд 51 албан албан шаардлага, 6,023.7 сая төгрөгийн 168 зөвлөмж, 272.3 сая төгрөгийн зөрчилд 11 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

III БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Говь-Алтай аймгийн Засаг даргын шилэн дансны цахим системд таван саяаас дээш орлого, зарлагын гүйлгээг мэдээлэх цэс байхгүй бөгөөд өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 59.5 сая төгрөгийн 8 захирамж, тушаалыг мэдээлээгүй бөгөөд хэрэгжилт 98 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаа дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтын дагуу 12,915.2 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсан нөхөн байршуулж мэдээлүүлсэн.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын залруулга:

- Шилэн дансанд 12,915.2 сая төгрөгийн мэдээллийг дутуу байршуулсан дараах байгууллагуудын мэдээллийг нөхөн мэдээлүүлсэн. (Халиун сум-2,223.8 сая, Тонхил сум-1,126.5 сая, Цогт сум-1,059.5 сая, Алтай сум-1,036.9 сая, Шарга сум-1,005.7 сая, аймгийн ЗДТГ-975.7 сая, Эрдэнэ сум-659.1 сая, Бугат сум-518.8 сая, Инновацн бизнес хөгжлийн төв УТҮГ-503.4 сая, аймгийн ИТХ-426.6 сая, Ундарга-Алтай ОНӨААТҮГ-360.4 сая, Дэлгэр сум-358.7 сая, Жаргалан сум-344.5 сая, Төгрөг сум-342.6 сая, Хөхморьт сум-309.6 сая, Дарив сум-294.7 сая, Байгаль орчны газар-268.0 сая, Алтай орон сууцны корпорацн ААТҮГ-184.6 сая, Чандмань сум-164.2 сая, Баянтоорой тосгон-128.8 сая, Гуулин тосгон-128.8 сая, Баян-Уул сум-118.7 сая, Тайшир сум-107.6 сая, Есөнбулаг сум-97.1 сая, Олон нийтийн алтай радио-67.3 сая, Цээл сум-29.3 сая, Солонго дулаан ААТҮГ-26.5 сая, Орон нутгийн өмчийн газар-17.6 сая төгрөг)

4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас төр, бүх шатны байгууллага, нийтийн алба тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж мөрдүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 987.5 сая төгрөгийн 38 зөрчил илэрснээс 35.5 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 128.8 сая төгрөгийн 5 зөрчил арилгах албан шаардлага, 823.2 сая төгрөгийн 28 зөвлөмж хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг баталсан. Уг журмын 2.1.4, 2.1.5, 2.1.6 заалтуудын дагуу аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгөөс сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь заалттай нийцэхгүй байна.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж **754.2 сая төгрөгийг** үр ашиггүй зарцуулсан. (аймгийн ЗДТГ-299.3 сая, Есөнбулаг сум-161.8 сая, Цогт сум-113.4 сая, аймгийн Засаг дарга данс -33.6 сая төгрөг, Бигэр сум-30.6 сая төгрөг, Халиун сум-24.3 сая төгрөг, Тонхил сум-19.7 сая төгрөг, Дарив сум-17.3 сая төгрөг, Чандмань-8.8 сая төгрөг, Алтай сум-6.9 сая төгрөг, Хөхморьт сум-5.3 сая төгрөг, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар-5.5 сая төгрөг, Төгрөг сум-5.1 сая төгрөг, Тайшир сум-4.6 сая төгрөг, Баян-Уул сум-4.2 сая төгрөг, Ундарга-Алтай ОНӨААТҮГ-4.1 сая төгрөг, Шарга сум-3.6 сая төгрөг, Дэлгэр сум-2.5 сая төгрөг, Эрдэнэ сум-2.2 сая төгрөг, Бугат сум-1.4 сая төгрөг)
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин аймгийн Засаг даргын орлогч, зөвлөх ажиллуулан **158.1 сая төгрөгийн** цалин олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан. (аймгийн ЗДТГ-115.2 сая төгрөг, аймгийн ИТХ-42.9 сая төгрөг)
- Төсвөөс **75.2 сая төгрөгөөр** компьютер тоног төхөөрөмж худалдан авахдаа цахимаас худалдан аваагүй. (Инноваци бизнес хөгжлийн төв УТҮГ-19.5 сая, Дарив сумын ЗДТГ-15.5 сая төгрөг, Жаргалан-Алтай өрхийн эрүүл мэндийн төв-10.8 сая төгрөг, Есөнбулаг сумын ИТХ-8.2 сая төгрөг, Шатрын сургууль-8.0 сая төгрөг, Хөхморьт сумын ЗДТГ-5.8 сая төгрөг, Халиун сумын ЗДТГ-4.9 сая төгрөг, Энх-Алтай өрхийн эрүүл мэндийн төв-2.5 сая төгрөг)

4.3 Бусад хууль тогтоомжийн хүрээн дэх нийцлийн аудитын асуудал:

Төсвийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, байгууллагын дотоод журамтай нийцэж байгаа эсэх асуудлыг энэ хүрээнд хамруулсан.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагаа зарлаагүй **877.7 сая төгрөгийн** худалдан авалт хийсэн. (Аймгийн ЗДТГ-438.1 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-247.9 сая төгрөг, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-64.5 сая төгрөг, аймгийн ИТХ-62.8 сая төгрөг, Халиун сумын ЗДТГ-39.4 сая төгрөг, Эрдэнэ сумын ЗДТГ-25.0 сая төгрөг)
- Орон нутгийн өмчит хуулийн этгээд Ундарга-Алтай ОНӨААТҮГ нь **588.5 сая төгрөгийн** алдагдалтай ажилласан,
- Төсөвт өртгийг хуваан босго үнээс доогуур хэсэгчлэн **238.0 сая төгрөгөөр** шууд худалдан авалт хийсэн. (аймгийн ИТХ)
- ЖДҮД Сангаас зээл олгохдоо төсөлд тавигдах шаардлагыг бүрэн хангаагүй төслийг санхүүжүүлсэн, төсөл сонгон шалгаруулах хурлыг аймгийн Засаг дарга удирдсан, тус сангаас олгосон **130.0 сая төгрөгийн** зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй,

- Малжуулалтын гэрээний дагуу 121.4 сая төгрөгийн малыг дараагийн айлд шилжүүлээгүй. (Халиун сумын ЗДТГ-94.0 сая, Баян-Уул сумын ЗДТГ-27.4 сая төгрөг)
- Байгууллагын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн төлөвлөгөөнд үйлдвэрлэл санхүүжилтийн төлөвлөгөө батлуулаагүй, төлөвлөгөөнд тусгаагүй 108.1 сая төгрөгийн зардал гаргасан. (Теле камерийн хяналтын дэд төв-98.1 сая, Ундарга-Алтай ОНӨААТҮГ-10.0 сая төгрөг)
- ИТХ-ын даргын захирамжаар 103.1 сая төгрөгийн төсвийн зарцуулалт хийсэн. (аймгийн ИТХ-83.3 сая төгрөг, Есөнбулаг сумын ИТХ-19.8 сая төгрөг)
- Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ нь 53.8 сая төгрөгийн худалдан авалтыг тендерт шалгараагүй, ирээн хуулийн этгээдээс худалдан авсан,
- Чандмань сумын ЗДТГ нь 23.7 сая төгрөгийг няравын дансаар дамжуулан гүйлгээ хийсэн,
- Дэлгэр сумын ЗДТГ-ын дарга албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн,
- Дэлгэр сумын ИТХ нь төсвөөс 1.0 сая төгрөгийн төлбөрийн актын төлбөрийг төлсөн,

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас зээл олгохдоо төсөлд тавигдах шаардлагыг бүрэн хангаагүй 9 иргэний 265.0 сая төгрөгийн төслийг санхүүжүүлсэн,
- Шинээр гэр бүл болсон малчин өрхийг малжуулах хөтөлбөрийн хүрээнд 128.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг сумдад олгон өмнөх зөрчлийг давтан гаргасан,

IV БҮЛЭГ. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт төсвийн дансаар 1,499.4 сая төгрөг төвлөрсөн нь өмнөх оноос 2.7 дахин буурсан үзүүлэлттэй байна. Учир нь өмнөх 2024 онд сумдын 100 жилийн ойтой холбоотойгоор аймгийн төсвөөс 14 сумд 1,400.0 сая төгрөгийг хуваарилсан.

Нийт нэмэлт төсвийн 67.0 хувь буюу 1,012.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргаас хуваарилсан, 33.0 хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр дараах орлогоос бүрджээ.

- Дээд шатны төсөв захирагчдаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө -729.9 сая төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж-136.0 сая төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого-351.3 сая төгрөг;
- ЗГНХ, ЗДНХ болон түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 282.1 сая төгрөг байна.

Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан боловч нэмэлт орлогын дансаар 2025 онд 351.3 сая төгрөг төвлөрч зарцуулсан.

Нэмэлт орлогоос 1,301.7 сая төгрөгийг дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Нэмэлт төсвийг зарцуулахдаа цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 13.5 сая төгрөг;
- Ажил олгогчоос төлөх НДШ 26.5 сая төгрөг;
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 9.1 сая төгрөг;
- Хангамж бараа материалын зардалд 97.7 сая төгрөг;
- Норматив зардалд 9.5 сая төгрөг;
- Эд хогшил, урсгал засварын зардал 65.4 сая төгрөг;
- Томилолтын зардалд 15.4 сая төгрөг;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 564.5 сая төгрөг;

- Бараа үйлчилгээний бусад зардалд 500.1 сая төгрөг;

Нэмэлт төсвөөс 197.6 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нийт нэмэлт төсвийн, 43.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 38.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан нь төсвийн дотоод хяналтыг сулруулах, төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- *Нэмэлт санхүүжилтийн дансаар 36.2 сая төгрөгийн хандив зөвшөөрөлгүй авч, зарцуулсан. (Хөхморьт сумын ЗДТГ-31.2 сая, Дарив сумын ЗДТГ-5.0 сая төгрөг)*

V БҮЛЭГ. ТӨСВИЙН ТОДОТГОЛ, ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ

5.1 Аймгийн төсвийн тодотгол

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 35 дугаар тогтоолоор нийт эх үүсвэрийг 74,917.1 сая төгрөгөөр баталсан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Говь-Алтай аймагт олгох татаас санхүүжилтийг 19,693.6 сая төгрөгөөр баталснаар улсын төсвөөс авах татаас санхүүжилтийг 9,991.6 сая төгрөгөөр, ОНХС-гийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 19,363.5 сая төгрөгөөр баталснаар 6,686.5 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргаас өргөн барьсан нийт төсөв 62,087.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг батлахдаа татварын болон татварын бус орлогыг 252.6 сая төгрөгөөр, ОНХС-гийн шилжүүлгийг 1,059.8 сая төгрөгөөр бууруулсныг урьд оны үлдэгдлээс 530.5 сая төгрөг, өөрийн орлогоос 529.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвт зохицуулалтыг хийсэн байна.

Өмнөх онд нийт эх үүсвэрийг 6,680.0 сая төгрөгөөр үндэслэлгүй нэмж баталснаас төсвийн орлого 5,380.0 сая төгрөгөөр тасарсан бол 2025 онд аймгийн ИТХ-аас анх баталснаас төсвийн орлого, зардлыг 12,829.7 сая төгрөгөөр бууруулж, ОНХС-гийн шилжүүлгийг 6,464.3 сая төгрөгөөр, сумдад олгох татаас шилжүүлгийг 3,565.1 сая төгрөгөөр, Засаг дарга Ерөнхий дансны зардлын төсвийг 2,689.7 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын ажлын албаны төсвийг 110.6 сая төгрөгөөр хасах тодотгол хийсэн байна.

Хүснэгт 13. Аймгийн 2025 оны төсвийн тодотгол

ҮЗҮҮЛЭЛТ				(сая төгрөг)		
	АИТХ-ын	ЗДТГ-аас	АИТХ-ын	Нэмсэн төсөв		
	2024.12.20 №35	өргөн барьсан	2025.08.21 №39	ЗДТГ-аас	ИТХ-аас	Нийт дүн
Татварын орлого	10,583.8	10,645.1	10,897.7	(252.6)	(313.8)	(313.8)
Татварын бус орлого	865.0	1,864.0	1,611.4	252.6	(746.5)	(746.5)
УТ-ын дэмжлэг	29,685.2	19,693.6	19,693.6	-	9,991.6	9,991.6
ОНХС-ийн шилжүүлэг	24,990.2	19,363.5	18,303.7	1,059.8	6,686.5	6,686.5
Урьд оны үлдэгдлээс	1,748.9	1,548.6	2,079.1	(530.5)	(330.2)	(330.2)
ЕБ сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого	6,514.8	8,972.6	8,972.6	-	(2,457.8)	(2,457.8)
өөрийн орлогоос	529.3	-	529.3	(529.3)	-	-

НИЙТ ЭХ ҮҮСВЭР	74,917.1	62,087.4	62,087.4	0.0	12,829.8	12,829.8
Аймгийн ИТХ	2,050.4	1,939.9	1,939.9	-	110.6	110.6
Засаг дарга	22,435.1	19,745.4	19,745.4	-	2,689.8	2,689.8
Хөрөнгө оруулалт	1,972.3	1,972.3	1,972.3	-	-	-
Сумдад олгох шилжүүлэг	22,631.5	19,066.4	19,066.4	-	3,565.1	3,565.1
ОНХС-ийн шилжүүлэг	25,827.8	19,363.5	19,363.5	-	6,464.3	6,464.3
НИЙТ ЗАРДАЛ	74,917.1	62,087.4	62,087.4	-	12,829.8	12,829.8

Эх сурвалж: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны тогтоол

Улсын төсвөөс авах татаас санхүүжилт 9,991.6 сая төгрөгөөр буурснаас сумдад олгох шилжүүлгийг 3,565.1 сая төгрөгөөр бууруулж, тайлант онд 4,311.5 сая төгрөгийн тогтмол зардлын богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Тайлант онд аймгийн ЗДТГ-т 21.0 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын Ерөнхий дансанд 63.5 сая төгрөгийн, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт дансанд 903.8 сая төгрөгийн, МСҮТ-ийн тогтмол зардалд 7.0 сая төгрөгийн, Биеийн тамир спортын газрын тогтмол зардалд 2.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт 10.6 сая төгрөгийн, Ахмадын хороонд 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг батлагдсан төсвөөс тус тус илүү олгосон.

Сум, байгууллага, дансдад санхүүжилтийг харилцан адилгүй хуваарилсан байна.

Төсвийн тодотголыг хийхдээ холбогдох хууль эрх зүйн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийг харгалзахгүйгээр үндэслэлгүй тооцон, аймгийн ИТХ-аас дахин нэмж баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2⁵ дахь заалтуудыг зөрчсөн байна. Цаашид баталсан хуваарийн дагуу төсвийн санхүүжилтийг хуваарилан олгодог байх шаардлагатай байна.

5.2 Төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлт, хэрэгжилт

Төрийн аудитын байгууллага нь тооцоо, судалгаандаа үндэслэн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх 1,425.2 сая төгрөгийн, урсгал болон хөрөнгө оруулалтын зардал бууруулах 6,854.4 сая төгрөгийн, үр ашгийг нэмэгдүүлэх 10 саналыг хүргүүлсэн.

Хүснэгт 14. Төсвийн төсөлд өгсөн санал, хэрэгжилт


Үзүүлэлт	Төсвийн санал		Саналын хэрэгжилт		
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь
Зардал бууруулах	7	6,854.4	-	-	-
Орлого нэмэх	4	1,425.2	-	-	-
Үр ашгийг нэмэгдүүлэх	10	-	-	-	-
Дүн	21	8,279.6	-	-	-

Эх сурвалж: 2025 оны төсвийн төсөлд хийсэн аудитын тайлан

Төсвийн төсөлд өгсөн саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээгүй, биелэлтийг ирүүлээгүй.

Аймгийн 2025 оны төсвийн нийт орлого 87,680.7 сая төгрөг, нийт зарлага 73,830.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө 13,850.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

5 Засаг дарга, хот, тосгоны Захирагч дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлнэ



Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэлийн хураангуй тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	(сая төгрөг)	
				Зөрүү /+хэмнэлт, - хэтрэлт/	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,182.1	73,830.5	16,351.6	81.8
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,244.4	87,581.9	(7,337.5)	109.0
	Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	9,937.7	(13,751.4)	23,689.1	

5.3 Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

Говь-Алтай аймгийн Засаг даргад өмнөх онуудын санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитаар өгсөн 2022 оны 08/195, 135/202, 151/202, 152/202, 162/202, 164/202, 165/202, 60/199 дугаар, 2024 оны 06/127 дугаар, 2025 оны 14/214, 04/208, 01/207, 02/208, 03/208 дугаар албан шаардлага, 3,671.6 сая төгрөгийн 43 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 2014 оны 09/01 дугаартай төлбөрийн актыг барагдуулаагүй, заасан хугацаанд биелэлтийг ирүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд шийдвэрийн биелэлт ирүүлэх хугацаа дууссан 2,397.9 сая төгрөгийн 110 зөвлөмж, 13,390.3 сая төгрөгийн 224 албан шаардлага, 1,070.3 сая төгрөгийн 162 төлбөрийн актын үлдэгдэлтэй байна.

Аймгийн Засаг даргаас аудитын шийдвэрийн хэрэгжээгүй үлдэгдлийг албан даалгавар гаргаж, ажлын хэсэг байгуулан хэрэгжилтийг хангуулах ажил зохион байгуулах талаар 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1/503 дугаар албан бичиг ирүүлсэн болно. Аудитын явцад 2019 оны 01/133, 2025 оны 02/107 дугаартай төлбөрийн акт, 1,292.4 сая төгрөгийн 10 зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн.

VI. НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНЭЛТ, ШИЙДВЭР

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар нийт 4,774.1 сая төгрөгийн 8 зөрчил⁶ илэрснээс, 2 албан шаардлага, 4,774.1 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлж, 2 зөрчлийг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгуулах, зөрчлийг давтан гаргасан Төсвийн ерөнхийлөн захирагчид дараагийн шатны арга хэмжээ авах саналыг Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжлав.

Аймгийн 2025 оны төсвийн орлогын 87,581.9 сая төгрөг, нийт зарлагын 73,830.5 сая төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.

Аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг нийт 41,420.2 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 6,126.1 сая төгрөгөөр, Сангийн яамны хянасан дүнгээс 9,284.3 сая төгрөгөөр, анх баталсан төсвөөс 16,400.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан;
2. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 6,759.6 сая төгрөгөөр буюу 116.0 хувиар давуулан биелүүлсэн нь өмнөх оны гүйцэтгэлээс 12,885.7 сая төгрөгөөр өссөн;
3. Улсын төсвөөс авах татаас санхүүжилт 9,991.6 сая төгрөгөөр буурснаас сумдад

⁶ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- олгох шилжүүлгийг 3,565.1 сая төгрөгөөр бууруулж, тайлант онд 4,311.5 сая төгрөгийн тогтмол зардлын богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй гарсан;
4. Нэмэлт төсөв 1,499.4 сая төгрөгийн 43.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд, 38.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 18.3 хувийг бусад зардалд зарцуулсан;
 5. Тонхил, Халиун сумууд нь ХХС-гийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг төсөвтөө төлөвлөөгүй, өмнөх зөрчлийг давтан гаргасан;
 6. Аймгийн хэмжээнд 17 байгууллага 312.1 сая төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын төсөв баталсан байхад гүйцэтгэлээр 28 байгууллага 809.2 сая төгрөг зарцуулж, 497.1 сая төгрөгийн төлөвлөөгүй зарлага гаргасан;
 7. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 800.0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн;
 8. Сангийн яамнаас хянаагүй Засаг дарга ерөнхий данснаас 2,073.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, сургалт, судалгаа болон буудал, албан томилолт, иргэн, төрийн бус байгууллагын дэмжлэг, бэлэг дурсгал, шагнал, урамшуулал зэрэг үйл ажиллагаанд зарцуулсан зөрчлийг давтан гаргасан байна.

6.1 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Дараах асуудлуудыг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд тусгуулж, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх саналыг уламжилж байна.

Үүнд:

1. Засаг дарга ерөнхий данснаас 2024 онд 3,438.4 сая төгрөгийг, 2025 онд 2,073.1 сая төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин, шагнал, урамшуулал, буцалтгүй тусламж, тэтгэмжид зарцуулсаар байна.
2. Аймгийн ИТХ-аас ОНХС-гийн эх үүсвэрээр 2024 онд 3,180.0 сая төгрөг, 2025 онд 3,200.0 сая төгрөг, 2026 онд 2,000.0 сая төгрөг, нийт 8,380.0 сая төгрөгийг төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрт зарцуулахаар баталсан. Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр заасан чиг үүрэгт хамаарахгүй, хориглосон буцалтгүй тусламж, дэмжлэгийн шинжтэй хөтөлбөр, арга хэмжээнд буюу эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдад 800.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон.

Энэ нь Нутгийн өөрөө удирдах байгууллага төсөв батлахдаа төсвийн зарчим, төсвийн нэгдмэл байдлыг алдагдуулсан шийдвэр гаргадаг, төсвийн захирагчид төсвөөс шагнал, урамшуулал, буцалтгүй тусламж, дэмжлэг олгодог зөрчлийг дахин давтан гаргасаар байна.

6.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвөөс шагнал, урамшуулал, буцалтгүй тусламж, тэтгэмж, дэмжлэгийг хавтгайруулан олгохгүй байх.
2. Төсвийн хэмнэлтийн бодлого, горимыг мөрдөж үр ашиггүй, тэвчиж болох зардлыг танах, хурал, сургалтыг цахимаар хийж, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй байх.
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу олгох.
4. ЖДҮД сангаас төсөл сонгон шалгаруулахдаа Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан журмыг мөрдөж ажиллах.
5. Төсвийн орлогын гүйцэтгэлээс шалтгаалсан эрсдэлийг тооцож, тогтмол зардлын төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулан, өр төлбөргүй ажиллах.

Хавсралт 1

**Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас
буцаан татан авсан зээлдэгчийн мэдээлэл**

№	Сумын нэр	Зээлдэгчийн овог нэр	Гэрээний дүн		Зориулалт	Буцаан татан авсан зээлийн мөнгөн дүн (төгрөг)	
			Зээл авсан дүн (төгрөг)	Эхлэх хугацаа			Дуусах хугацаа
1	Алтай	Буурал аж богд хоршоо	44,000,000.00	9/29/2011	10/5/2014	Үйлдвэрлэл эрхлэх, хоршоо хөгжүүлэх	18,200,000.00
2	Дэлгэр	Ж.Бат-эрдэнэ	10,900,000.00	3/26/2015	3/26/2018	фото зураг хэвлэл, Компьютер	2,692,728.00
3	Дэлгэр	Ж.Бат-Эрдэнэ	3,465,000.00	7/30/2015	7/30/2018	фото зураг, компьютер үйлчилгээ	4,329,431.00
4	Хөхморьт	М.Төрмөнх	8,000,000.00	12/24/2011	10/1/2014	Чацаргана	6,876,637.00
5	Хөхморьт	Х.Даш	4,500,000.00	10/26/2011	12/1/2013	Оёдол	2,648,657.00
6	Цогт	Б.Мөнхжаргал	5,000,000.00	6/15/2014	6/15/2017	Дугуй засвар	4,520,867.00
7	Цогт	Бат-Эрдэнэ	5,000,000.00	7/28/2016	7/28/2019	Чацаргана	5,086,929.00
8	Чандмана	Ханжид баян булаг	20,000,000.00	10/1/2013	10/1/2016	Улаан тоосго	13,388,466.00
9	Эрдэнэ	Г.Батзориг	15,000,000.00	7/1/2015	7/1/2017	Түүхий эд боловсруулах	4,850,000.00
10	Есөнбулаг	Б. Алтанзүл	5,000,000.00	7/4/2013	2016\07\03	кафе шол	3,716,027.00
11	Есөнбулаг	Д. Лхагвасүрэн	10,000,000.00	7/5/2013	2016\07\03	модон эдлэл үйлдвэрлэл	3,345,000.00
12	Есөнбулаг	Н. Бямбаа	3,000,000.00	10/22/2014	2017\11\03	Оёдлын үйлдвэрлэл үйлчилгээ	1,779,264.00
13	Есөнбулаг	А. Мөнхтөр	15,000,000.00	10/22/2014	2017\11\03	монгол оймс үйлдвэрлэл	16,551,429.00
НИЙТ ДҮН			148,865,000.00				87,985,435.00